



Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар 2020 оныг Зам, тээврийн салбарын хэмжээнд “Сахилга хариуцлага-Хөдөлмөрийн аюулгүй байдлын жил” болгон зарласантай холбоотой **“ГТХЗНТ” УТҮГ нь “ЧАДВАРЛАГ АЖИЛТАН-АЮУЛГҮЙ АЖЛЫН БАЙР”-ыг дэмжих жил болгон зарласан.**

**Чадварлаг ажилтны хүрээнд:** Ажилтнуудын гадаад хэлний мэдлэгийг сайжруулах зорилгоор ажлын байран дахь англи хэлний онлайн болон танхимын сургалт, давтлага, тараах материал, хуулан бичлэг, сонсох дасгал, яриа уншлага зэрэг хичээлийг 33 удаа, хууль тогтоомжийн мэдлэг олгох, хууль тогтоомжийг сурталчлах таниулах болон бусад сургалт, мэдээллийн арга хэмжээг 18 удаа зохион байгуулсан. Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвөөс 2020.09.02-04-нд зохион байгуулсан "Чадамжийн үнэлгээ баталгаажуулалтын ажилтан бэлтгэх модуль-3" сургалтад 1, Иркутскийн ЗХУИХСургуулийн орос хэлний бэлтгэл курсын Microsoft teams, Moodle програмын 15 өдрийн онлайн сургалтад 3 ажилтан, СХЗГ-аас зохион байгуулсан “Стандарчилалын суурь ойлголт сэдэвт сургалтад 3 ажилтан, КОЙКА олон улсын байгууллагаас зохион байгуулсан “Төмөр замын мэдлэг олгох” сургалтад 6 ажилтан, “Microsoft Teams” програмаар /онлайн/ алсын зайнаас зохион байгуулсан мэдээллийн технологийн магистрын сургалтад 3 ажилтан тус тус хамрагдсан.

**Аюулгүй ажлын байрны хүрээнд:** ГТХЗНТ-ийн ХАБЭА-н төлөвлөгөө баталж түрээслүүлэгч байгууллагаар их засвар, тохижилтын ажил болон "УБ ариутгал" ХХК-иар 2 удаагийн ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийлгэсэн. Ажлын байранд цахилгаан соронзон долгион үүсэх эрсдлийг бууруулж цахилгааны монтажиг шинэчилж цахилгаан газардуулга хийлгэсэн. Ажлын байранд аюултай хог хаягдлыг ангилан хадгалах агуулах гаргаж, ашиглалтын хугацаа дууссан процессорин ваттерейг салгаж, ашиглагдсан принтерийн хорны хаягдлыг ангилан хадгалж байна. Мөн ашиглалт дууссан ахуйн зай хураагуурыг хадгалах сав байршуулсан. Ажлын байрны цэвэр усны шугамд ус цэвэршүүлэгч холбож, ажилтныг амны цэвэр усаар хангаж, цахилгаан соронзон долгионыг саармагжуулах зорилгоор агаар чийгшүүлэгч, ууршуулагч 5 ширхэгийг худалдан авч, ажлын байранд байршуулсан. Ажлын байранд агаар цэвэршүүлэх цэцэгт ургамлуудыг үрслүүлэн тариалж байршуулсан. Ажлын байрны цонхны салхивчинд ялаа шумуулнаас хамгаалах тор татаж, цонхоо угааж цэвэрлэх арга хэмжээ зохион байгуулсан. ХАБЭА-н өдөр тутмын зааварчилгааг видео хэлбэрт оруулж ажилтан бүрийн ажлын компьютерт асаах бүрт тоглогдох заавартайгаар суулгаж, зааварчилгаа авсан талаар өдөр бүр гарын үсэг зуруулан баталгаажуулж байна. Ажилтнуудын дархлааг дэмжих зорилгоор витаминжуулах арга хэмжээ зохион байгуулж, ХАБЭА-н 2 шатны хяналтын үзлэгийг тухай бүр зохион байгуулж ажлын байранд учирч болзошгүй аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийж ЗТХЯ-нд танилцуулсан.



### Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын 2019 оны үйл ажиллагааны тайлан хамгаалах хуралд оролцлоо



Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын 2019 оны үйл ажиллагааны тайлан хамгаалах хурал 2020 оны 02 дугаар сарын 14-17-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн яаманд зохион байгуулагдлаа.

Харьяа байгууллагуудын үйл ажиллагааны тайлан хамгаалах хурлын хуваарийн дагуу “ГТХЗНТ” УТҮГ нь тодорхой үр дүн харуулах хэмжээнд хийгдсэн, шийдвэрлэгдсэн, зохион байгуулсан, үр дүн нь гарсан ажлуудын гүйцэтгэлийг яамны удирдлагуудад танилцуулав.



Тайлан хамгаалах хуралд Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Дэд сайд Л.Халтар, Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Бодлого, төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Мөнхнасан, Төрийн захиргааны удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Болор-Эрдэнэ, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Артур, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга М.Энхболд, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн Л.Шинэчимэг, “ГТХЗНТ” УТҮГ-ын захирал А.Буяннэмэх, Тээврийн нэгдсэн удирдлага, автоматжуулалт, судалгааны хэлтсийн дарга Д.Төгсжаргал, мэргэжилтэн Э.Осоржамаа нар оролцлоо.



Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаал, “ГТХЗНТ” УТҮГ-ын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, шилэн дансны хөтлөлт, ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүд зэрэг үйл ажиллагаа 2019 оны жилийн эцсийн байдлаар 91.2 хувийн биелэлттэй дүгнэгдэж, яамны удирдлагын зүгээс “ГТХЗНТ” УТҮГ-ын үйл ажиллагаатай холбогдуулан тодорхой үүрэг даалгавар, бодлогын чиглэл өглөө.





Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төгсгөлийн хэсгийн өртөөдийг хэрхэн зохион байгуулах тооцоо судалгаа, зураг төслийн ажлын даалгавар боловсруулах ажлын хэсгийн хүрээнд:


“2020 оны 02-р сарын 04-ны өдөр ЗТХЯ, УУХҮЯ, “ГТХЗНТ” УТҮГ, “МТЗ” ТӨХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК болон уул уурхайн төлөөллүүд оролцсон хэлэлцүүлгийг УУХҮЯ-аман дээр зохион байгуулж, төвийн захирал А.Буяннэмэх “Зүүнбаян-Тавантолгой чиглэлийн төгсгөлийн өртөөдийн зураг, төслийн даалгавар”-ын тухай танилцуулан, төгсгөлийн өртөөдийн зохион байгуулалт, техникийн өртөөний ач холбогдлын тухай нээлттэй хэлэлцсэн.

“УБТЗ” ХНН болон “РЖД Интернэйшил” ХХН талууд “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд техникийн зөвлөгөө үзүүлэх тухай” гэрээнд гарын үсэг зурсан.



**2020 оны 02 дугаар сарын 05-ны өдөр** ЗТХЯ-нд төмөр замын салбарын удирдлагууд төслийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн, “РЖД Интернэйшил” ХХН-ийн төлөөллийг хүлээн авч уулзалт зохион байгуулж, Төвийн захирал төвийн хэмжээнд хийгдсэн ажлуудыг танилцуулсан.

“Мосгипротранс” ХН-ийн Гадаадын төсөл, хөдөлгөөн зохион байгуулалтын хэлтсийн дарга Николай Васильевич Төвийн захирал А.Буяннэмэх нар тусгайлан уулзаж Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтанд Төвийн чиг үүргийн хүрээнд хийгдсэн тооцоо, судалгаа, зураг төслийн талаар хэлэлцэж, цаашид хийгдэх ажлуудын талаар санал солилцсон.





Шинэ төмөр замуудын холболт, төмөр замын технологийн барилга байгууламжийн төлөвлөлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүд томилолтоор ажиллаа.

ЗТХСайдын 2020 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн А/130 дугаар тушаалаар байгуулагдсан Гашуунсухайт–Тавантолгой, Тавантолгой–Зүүнбаян–Сайншанд, Сайншанд–Баруун-Урт–Хөөт чиглэлийн төмөр замуудын холболт, Дорноговь, Өмнөговь аймгийн бүс нутаг дахь шинэ төмөр замын технологийн барилга байгууламжийн төлөвлөлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүд 2020 оны 07 дугаар сарын 22-ны өдөр Өмнөговь аймгийн Цогтцэций суман дахь өртөөдийн байршил, технологийн барилга байгууламжийн төлөвлөлтөд шинжилгээ хийх, төгсгөлийн өртөөдийн болон төмөр замуудын холболтын цэгийг тодорхойлох, 08 дугаар сарын 07-ны өдөр Дорноговь аймгийн Сайншанд суманд Тавантолгой–Зүүнбаян–Сайншанд–Баруун-Урт чиглэлийн төмөр замуудын холболт, технологийн байгууламжийн төлөвлөлтийг тодорхойлох зорилгоор газар дээр нь судалгаа хийж, оновчтой хувилбаруудыг боловсруулан дүгнэлт гарган ажилласан.

2020.07.22, 2020.08.05, 2020.08.07, 2020.08.14, 2020.08.20-ны өдөр тус тус хуралдаж шинэ төмөр замуудын холболтыг тодорхойлох санал дүгнэлтийг боловсруулж 2020.08.21-ний өдөр ЗТХ-ийн сайдад танилцуулсан.







### “БТЕГ” ХХК болон “УБТЗ” ХНН-ийн төлөөлөгчтэй уулзалт зохион байгууллаа.

Төв нь “БТЕГ” ХХК болон “УБТЗ” ХНН-ийн удирдлага болон мэргэжилтнүүдийг хүлээн авч ирээдүйд хэрэгжүүлэхээр зорьж буй төсөл хөтөлбөр, төвийн зорилго, зорилтыг танилцуулж, төсөлтэй холбогдуулан ОХУ-ын Эрхүү хотын зам харилцааны их сургуульд мэдээлэл технологийн чиглэлээр магистрын эчнээ хөтөлбөрт инженерүүдийг хамруулах, хамтран ажиллахыг уриалан ажилласан.





Зам, тээврийн мэргэжлийн боловсрол сургалтын төмөр замын дэд салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд орж хамтран ажиллаж байна.



“ГТХЗНТ” УТУГ нь Зам, тээврийн мэргэжлийн боловсрол, сургалтын салбар зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн тогтоолоор Зам, тээврийн мэргэжлийн боловсрол сургалтын төмөр замын дэд салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд орж хамтран ажиллаж байна.

Монгол Улсын хэмжээнд олон төмөр замууд бий болж шинэ техник, технологи, үйлчилгээ эрчимтэй нэвтэрч, үүнийг даган шинэ мэргэжлүүд гарч байгаатай холбоотойгоор “Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08”-д нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага бий болж байна.



Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт 08-д нэмэлт, өөрчлөлт оруулах, нийцүүлэх, орхигдсон ажил мэргэжлийг нэмж кодчлох зорилгоор “УБТЗ” ХНН-ийн суурь бааз дээр тулгуурлан хийсэн судалгаанд 463 ажил мэргэжлийн 11872 ажилтан ажиллагсад хамрагдсанаас 429 ажил мэргэжлийн 5730 орон тоон нийцүүлэн кодонд оруулж, 34 ажил мэргэжлийн 6142 орон тоог шинээр код үүсгэн оруулсан ба Үндэсний ажил мэргэжлийн тодорхойлолт-08-д нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх саналын маягтын хамтаар Мэргэжлийн боловсрол сургалтын төмөр замын дэд салбар зөвлөлд 2020.06.03-ны 124 тоот албан бичгээр хүргүүлж МБСЗ-ийн Зам, тээврийн салбар зөвлөлийн 2020.06.04-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн.

Төмөр замын дэд салбар зөвлөлийн гүйцэтгэсэн төмөр замын салбарын ажил мэргэжлийн жагсаалтыг холбогдох байгууллагад уламжлах тухай хүсэлтийг 2020.06.08-ны 129 тоот албан бичгээр ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020.06.26-ны өдрийн “Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай А/152 дугаар тушаалаар батлагдсан







Корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгууллаа.

Шинэ төрлийн Корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор төвийн хэмжээнд халваргүйжүүлэлт, ариутгал хийж байна. Нийт ажилтнуудад дархлаа дэмжих бүтээгдэхүүнийг олгож, гар ариутгалын бодис, маскны хайрцаг, нэг удаагийн маскийг тогтмол тарааж, өрөөний ариутгалыг 2 цаг тутамд хийж байна. “МАСК ДАВАЛГАА- АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ БИД БИЙ БОЛГОНО” уриалгыг гаргаж, нийт ажилтнуудад вирусын халдвараас урьдчилан сэргийлэх зурагт хуудас, мэдээ мэдээллийг танилцуулан, ажилтны биеийн халууныг өдөр бүр хэмжиж, ухуулга хуудас, зөвлөмжүүдийг ажлын байранд байршуулан ажилласан.



УБТЗ-ын Төв эмнэлэгт 1000 ширхэг нэг удаагийн бээлий, 192 ширхэг ариутгагч хандивлалаа.

Дэлхий нийтэд тархаад байгаа Шинэ коронавирусыг /COVID-19/-ын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний хүрээнд “ГТХЗНТ” УТҮГ нь УБТЗ-ын Төв эмнэлэгт 1000 ширхэг нэг удаагийн бээлий, 192 ширхэг ариутгагч хандивлалаа.





Тохирлын үнэлгээ, үл эвдэх сорилын лаборатори байгуулах ажлын судалгаа хийх ажлын хүрээнд төмөр замын салбарын тохирлын үнэлгээ, үл эвдэх сорилын лабораторийн өнөөгийн байдлын тухай танилцуулга бэлтгэж төвийн удирдлагад танилцуулсан.

Үүнд: тохирлын үнэлгээний эрхзүйн орчин, холбогдох стандартууд, ОХУ-ын гэрчилгээжүүлэлт, лицензийн тухай, “УБТЗ” ХНН-ийн тохирлын үнэлгээний нөхцөл байдал, барилгын төмөр бетон бүтээц болон хиймэл төхөөрөмжийн тохирлын үнэлгээний орчин, хэмжилт туршилтын лабораториуд, цаашид төвийн зүгээс тохирлын үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага болох төлөвлөгөө зэргийг танилцуулсан.

Үл эвдэх сорилын лаборатори манай улсын хэмжээнд МИАТ компани, Оюу толгой компаниудад иж бүрнээр ажил үүрэг гүйцэтгэж, сорилт туршилт хийж байна. Төмөр замын салбарын үл эвдэх сорилын лабораторийг төвийн барилга баригдсаны дараа түүний суурийн давхарт байгуулах боломжтой талаар судалж Япон улсын “Жайка” Олон улсын хамтын ажиллагааны байгууллагад танилцуулсан. Бид төмөр замын салбарын зам төмөр, төмөр бетон дэр, гүүр хоолойн төмөр бетон бүтээц, хөдлөх бүрэлдэхүүн, хөлдөх бүрэлдэхүүний хариуцлагатай эд ангид тохирлын үнэлгээ хийж тохирлын баталгааны гэрчилгээ өгөх шаардлагатай байна.

Зам тээврийн, хөгжлийн сайдын 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 161 дугаар тушаалын дагуу ГТХЗНТөв нь ЗТХЯ-тай хамтран төмөр замын салбарт тохирлын үнэлгээний талаар гаргасан бичиг баримтуудыг сайжруулан, олон улсын жишигт хүргэж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Төмөр замын шинэчилсэн найруулгын төсөлд нэмэлт өөрчлөлтийг тусгасан. Уг өөрчлөлтийн гол нь ГТХЗНТөвийг салбарын итгэмжлэгдсэн лабораториудын ажиллагаанд тулгуурлан тохирлын үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага болгохоор хуульчлах зорилт тавин ажиллаж Монгол улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх хүлээлцэх журамд түрээсийн хөдлөх бүрэлдэхүүний талаар заалт оруулсан.

Одоогийн байдлаар тохирлын үнэлгээний талаар хийгдэж буй ажлуудаас дурдвал ЗТХЯ-наас хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй байдлын гэрчилгээ олгох, бүтээгдэхүүний хувьд төмөр бетон дэр, гүүрийн дам нуруу, барилгын бетон хийцийн тохирлын үнэлгээний гэрчилгээг БАК (барилга архитектур корпорац) ISO/IEC17065, ISO/IEC17067 стандартаар олгож байна.







**Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл, төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ**

Тусгай зөвшөөрөл шинээр авах, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах нийт 68 өргөдөл ирсэн. Ажлын хэсгийн 12 удаагийн хурлаар 73 хуулийн этгээдийн өргөдөл, хүсэлтийг хэлэлцэж төмөр замын тээврийн үйл ажиллагааны 21 тусгай зөвшөөрөл шинээр олгож, 3 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах асуудлыг ЗТХ-ийн сайдын 2020 оны А/117, А/141, А/170, А/180, А/188, А/216 дугаар тушаалаар шийдвэрлүүлсэн. Ажлын хэсгээс дэмжин ЗТХЯ-нд уламжилсан 22 өргөдөл байна. Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүд, тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааны төрөл, ангилалаар мэдээллийн сан бүрдүүлсэн.

2020.12.01-ний өдрийн байдлаар гэрчилгээжүүлэлттэй холбоотой 107 хүсэлт ирсэн бөгөөд ажлын хэсгийн 13 удаагийн хурлаар 99 хуулийн этгээдийн хүсэлтийг хэлэлцэж 8 хуулийн этгээдэд 55 гэрчилгээ шинээр олгож, 68 хуулийн этгээдийн 291 гэрчилгээний хугацааг сунгаж, 2 хуулийн этгээдийн 2 гэрчилгээнд өөрчлөлт оруулах асуудлыг ЗТХ-ийн 2020 оны А/115, А/116, А/135, А/146, А/151, А/169, А/189, А/194, А/198, А/212 дугаар тушаалаар шийдвэрлүүлсэн. Ажлын хэсгээс дэмжин ЗТХЯ-нд уламжлан шийдвэрлэгдэх шатанд 11 хүсэлт 123 гэрчилгээ байна. Гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн сан бүрдүүлж хөтөлсөн.



**Монгол улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд шинээр дугаар олгох, шинэчлэх, баталгаажуулах, мэдээллийн санд бүртгэх**

Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журмын 6.2-т заасны дагуу төмөр замын тээврийн салбарт ашиглагдаж буй хөдлөх бүрэлдэхүүний тайлан мэдээллийг 2020.01.03-ны 03, 2020.07.07-ны 174 тоот албан бичгээр ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-т танилцуулсан. Хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, түрээслэгч нараас ирүүлсэн 22 хүсэлт, өргөдлийг шийдвэрлэж 7 хуулийн этгээдийн 496 хөдлөх бүрэлдэхүүнд (зорчигчийн вагон 273, зүтгүүр 74, тавцант вагон 74, хоппер 57, хагас вагон 14, цахилгаан түлхэгч 3, битүү вагон 1) шинээр дугаар олгож, 5 хуулийн этгээдийн 259 (хагас вагон 124, цистерн вагон 110, тусгай загварын вагон 25) хөдлөх бүрэлдэхүүний дугаарыг баталгаажуулж мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, 1 хуулийн этгээдийн ОХУ-аас түрээслэж төмөр замын тээвэрлэлтэд ашигласан ачааны 50 хагас вагоны дугаарыг мэдээллийн нэгдсэн сангаас хассан.

Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хяналт тавих, хүлээлцэх үйл ажиллагаанд ГТХЗНТ-ийн оролцоог хангаж “Их Уул менежмент” ХХК-ийн ОХУ-аас түрээслэх 50, “Талын хишиг майнинг” ХХК-ийн 90 хагас вагон, “Тонж ложистик” ХХК-ийн 60 цистерн вагоныг төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах эсэхийг шалган, дүгнэлт гаргах үүрэг бүхий ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020.03.02-ны өдрийн А/37, 2020.04.03-ны өдрийн А/55, 2020.05.05-ны өдрийн А/67 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ГТХЗНТ-ийн төлөөлөл ажилласан.


## Томилолт



Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгохтой холбоотой ажлын хэсэг томиллолтоор хөдөө орон нутагт ажиллаа.

Гэрчилгээ хүссэн өргөдлийг нягтлан шалгах, санал дүгнэлт гаргах ажлын хэсэг Сэлэнгэ аймгийн Хүдэр, Ерөө, Сайхан, Мандал сумын нутаг дэвсгэрт байрлах төмөр замын өртөө, депо, үйлдвэрт 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 2020 оны 07 дугаар сарын 03-ны өдрийг хүртэл албан томиллолтоор ажилласан.

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт байрлах “Монголын төмөр зам” ТӨХК-ийн харьяа Төмөртэй өртөө, Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах “БТЕГ” ХХК-ний Вагон засварын депо, Сайхан сумын нутагт байрлах “Цемент шохой” ХХК болон “УБТЗ” ХНН-ийн харьяа Хөтөл дэх Төмөр бетон дэрний үйлдвэр, Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт байрлах Зүүнхараа дахь Ачааны вагон засварын депогийн үйл ажиллагаатай танилцаж, техникийн бүрэн бүтэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах эсэхийг шалган гэрчилгээ сунгуулах хүсэлт бүхий баримт бичгийн бүрдлийг хянан дүгнэлт гарган ажилласан.







“Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой ажлын хэсэг томилолтоор хөдөө орон нутагт ажиллаа.

Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой ажлын хэсэг 2020 оны 06 сарын 30-наас 07 дугар сарын 02-ныг дуустал Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт эхэлсэнтэй холбоотойгоор тусгай зөвшөөрлөө авсан эрх бүхий албан байгууллагын үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцсан.

“УБТЗ” ХНН-ийн Сайншанд өртөөний үйл ажиллагаа болон Дорноговь, Өмнөговь аймгуудын нутаг дэвсгэрт байрлах щебень /замын чигжээс/-ний үйлдвэрүүдтэй танилцан, чулуулгийн олборлолт, олборлосон чулуулгийг дээж авч чанарын шинжилгээнд /лабораторийн/ хэрхэн хамруулж байгаа, үйлдвэрийн үйл ажиллагаа, техник бүрэн бүтэн байдлыг шалган санал бодлоо солилцож, цаашид авах арга хэмжээ талаар санал боловсруулан ажилласан.



## Мэдээ, мэдээлэл



“ГТХЗНТ” УТҮГ нь Монголын Тээвэр Зуучлагчдын Нэгдсэн холбоотой санамж бичиг байгууллаа .

“ГТХЗНТ” УТҮГ-ы захирал А.Буяаннэмэх МТЗНХ-н Удирдах зөвлөлийн дарга П.Солонго нар 2020.08.13-ны өдөр "Хамтын ажиллагааны санамж бичиг"-т гарын үсэг зурлаа. Улмаар талууд төмөр замын тээвэр зуучлал, логистикийн салбарыг хөгжүүлэх, зардлыг бууруулах арга замуудыг тодорхойлж ажил хэрэг болгохыг шуурхайлах, салбарын системийн мэдээлэл технологийн тал дээр идэвхи гарган ажиллахаар санал нэгдэв.









"Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээний нэгдсэн санг бүрдүүлэн ажиллаж байна.




Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг хэрэгжүүлж төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна. 2020.12.04-ний өдрийн байдлаархоногийн 2688, долоо хоногийн 108, сарын 76, улирлын 40, жилийн 25, нийт 2937 мэдээг салбарын мэдээллийн нэгдсэн санд бүрдүүлж төвлөрүүлсэн.

Хөдлөх бүрэлдэхүүний парк ашиглалтын, суурь бүтцийн техникийн хүчин чадлын үзүүлэлтийн, төмөр замын байгууллагын ажилтан, албан хаагчдын тоо, боловсролын түвшний, төмөр замын сүйрэл, ослын, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын жилийн мэдээг ТЗ 1,2,3,4,5 маягтаар ЗТХЯ-ны БТГ, ТЗДТБХЗГ-т тоот албан бичгээр, ҮСХ-нд цахим шуудангаар хүргэж танилцуулсан. Төмөр замын тээврийн сүйрэл, осол, гологдлын 2020 оны 1, 2, 3 дугаар улирлын мэдээг ТЗ-4 маягтаар ЗТХЯ-ны ХШҮДАГ-т албан бичгээр танилцуулсан. Төмөр замын тээврийн 2019 оны XII, 2020 оны I, II, III, IV, V, VI, VII, VIII, IX, X, XI сарын тээвэрлэлтийн мэдээг улсын тайлан Т-9 маягтаар, албан бичгээр ЗТХЯ-ны БТГ, ТЗДТБХЗГ-т хүргэж танилцуулсан. 2020 оны эхний хагас жилийн тээвэрлэлтийн тоон мэдээ дүн шинжилгээний тайланг албан бичгээр ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-т хүргүүлсэн. Цахим засаглал үндэсний хөтөлбөрийн хүрээнд зам, тээврийн салбарын статистик мэдээллийн нэгдсэн системд төмөр замын тээвэрлэлтийн 54, төмөр замын ашиглалтын ажлын үндсэн үзүүлэлтийн 66, дамжин өнгөрөх ачааны 3, ачилтын 28 мэдээллийг байршуулсан. 2019 оны XII, 2020 оны I, II, III, IV, V, VI, VII, VIII, IX, X, XI сарын




статистик мэдээ, мэдээллийг нэгтгэж нийгэм, эдийн засгийн байдалд нөлөөлсөн байдлаар буюу төмөр замын ачаа, зорчигч тээвэрлэлт, ачаа ачилт, зорчигч, ачаа эргэлт, дамжин өнгөрсөн болон тээвэрлэсэн ачаа, галт тэрэгний зурмагийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, ЗТХЯ-ны [www.mrtcc.gov.mn](http://www.mrtcc.gov.mn) цахим хуудаст инфографик хэлбэрээр байршуулж олон нийтэд нээлттэй, ил тод мэдээллээ.

## Төмөр замын тээврийн үндсэн үзүүлэлт




2020 оны арван нэгдүгээр сард 73.8 мян.зорчигч 2548.9 мян.тн ачаа тээвэрлэсэн байна.

## Ачилт - ачааны төрлөөр /2020 оны 11 дүгээр сард/



## Дамжин өнгөрсөн ачаа /мян.тн/



2020 оны арван нэгдүгээр сард 375.4 мян.тн ачаа дамжин өнгөрсөн байна.

Ачилтаар 2020 оны арван нэгдүгээр сард нүүрс, төмрийн хүдэр, зэс, молибдений баяжмал өссөн үзүүлэлттэй байна. Нийт 1537.0 мян.тн ачсан байна.




Нүүрс	49%
Төмрийн хүдэр	31%
Бусад ачаа	2%
Барилгын материал	6%
Жонш	3%
Зэс, молибдений баяжмал	3%
Нефтийн бүтээгдэхүүн	3%



2020 оны 11 дүгээр сард өссөн дүнгээр 1965.7 мян.зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс -27.8-аар буурсан, 27423.8 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 7%-аар өссөн үзүүлэлттэй байна.





## ИНФОГРАФИК





Галт тэрэгний хөдөлгөөний зун, өвлийн нэгдсэн зурмаг боловсруулж батлах, галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн тасалдалд дүн шинжилгээ хийж, тайлан мэдээг танилцуулах

Ковид-19 цар тахлын тархалттай холбогдуулан Засгийн газрын тогтоол, УОК-ын хурлын тэмдэглэлийн хүрээнд бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасан, ЗТХ-ийн сайдын тушаалаар коронарусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байгаатай холбогдуулан галт тэрэгний хөдөлгөөний зуны цагийн хуваарьт шилжих боломж бүрдэхгүй байсаар “УБТЗ” ХНН нь олон улсын болон орон нутгийн зорчигчийн, дамжин өнгөрөх болон орон нутгийн ачааны галт тэргийн цагийн хуваарь, зурмагийн төслийг хэсэгчлэн ирүүлснийг нэгтгэж галт тэрэгний хөдөлгөөний 2020 оны зуны нэгдсэн зурмагийг боловсруулж 2020.06.09-ний өдөр баталсан. Нэгдсэн зурмагийг “УБТЗ” ХНН, “МТЗ” ТӨХК, “БТЕГ” ХХК-д албан бичгээр хүргүүлж мөрдөж ажиллахыг мэдэгдэн ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-т албан бичгээр хүргэж танилцуулсан. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн тасалдалд дүн шинжилгээ хийж 2019 оны хөдөлгөөний зурмагийн тасалдлын тайланг, 2020 оны I, II, III улирлын хөдөлгөөний зурмагийн тасалдлын тайланг, галт тэрэгний хөдөлгөөний IY, Y, YI, YII, YIII, IX, X сарын зурмагийн тасалдлын тайланг албан бичгээр ЗТХЯ-ны ХШУДАГ-т, суурь бүтэц дэх 2019-2020 оны өвлийн галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийсэн ажлын тайланг албан бичгээр ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-т танилцуулж төмөр замын байгууллагуудад хүргүүлсэн. ЗТХ-ийн сайдын 2020.08.17-ны өдрийн А/154 дүгээр тушаалын наймдугаар хавсралтаар батлагдаж захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 2020.08.27-ны өдрийн 4856 дугаар бүртгэгдсэн “Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журам”-д заасны дагуу галт тэрэгний хөдөлгөөний 2020-2021 оны өвлийн нэгдсэн зурмагийг боловсруулж 2020.10.20-ны өдөр баталж, мөн өдрийн 313 тоот албан бичгээр ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-т танилцуулж, суурь бүтцүүдэд мөн өдрийн 314 тоот албан бичгээр хүргүүлж мөрдөж ажиллахыг мэдэгдэн гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.







## “Төрийн албаны тухай хууль”-ийн сургалтад хамрагдлаа.

Төвийн нийт ажилтан, албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, эрх зүйн аливаа маргаанаас урьдчилан сэргийлэх, тогтмол мэдээ мэдээллээр хангах үүднээс сар болгон хууль сурталчлан таниулах сургалт арга хэмжээ зохион байгуулж байна. Энэ ажлын хүрээнд сард “Төрийн албаны тухай хууль”-ийн сургалтад нийт ажилтан, албан хаагчид хамрагдсан.



## “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль” сэдвээр сургалт зохион байгууллаа.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, “Нийслэл адвокатс” ХХН-тэй хамтран “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль” сэдвээр сургалт, мэдээллийн арга хэмжээ зохион байгуулж нийт ажилтныг хамруулав.





## Нийт ажилтан албан хаагчдыг хамруулсан сургалт

“Авлигын эсрэг хууль” сэдвээр 2020.02.11-ний өдөр, “Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр 2020.05.20-ны өдөр, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль сэдвээр 2020.07.07-ны өдөр сургалт, мэдээллийн арга хэмжээ зохион байгуулж нийт ажилтныг хамруулсан. зорилгоор “Ёс зүйтэй хамт олон” сарын аяныг зохион байгуулж, аяны хүрээнд төвийн ажилтнуудад “Авилгын тухай хууль, зөрчлийн тухай хууль, ёс зүйн зөрчил, түүний тухай ойлголт, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдвээр сургалт мэдээллийн арга хэмжээг 02 дугаар сарын 11, 20-нд зохион байгуулж, байгууллагын соёл, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаар ажилтнуудаас 2020.02.10-нд сэтгэл ханамжийн судалгаа, 2020.05 сард ажилтны стрессийн судалгаа, байгууллагын соёл, хамт олны уур амьсгалын талаарх сэтгэл ханамжийн судалгаа, 2020.08 сард төвийн ажилтны ёс зүйн судалгаа зэрэг судалгаануудыг нийт ажилтнаас авч, судалгааны тайланг танилцуулсан. “Нийслэл адвокатс” хуулийн фирмтэй хамтран Монгол Улсын хууль тогтоомжийг таниулах, сурталчлах ажлын байран дахь 18 удаагийн сургалт, мэдээллийн арга хэмжээ, “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” УТҮГ-тай хамтран “Агаарын бохирдол, аюултай хог хаягдал” “монгол улсын модны нөөц, мод тарих арга зүй” сэдэвт танин мэдэхүйн 2 удаагийн сургалт, “Эхлэл академи”-с 2020.02.15-нд зохион байгуулсан 30 хоногийн үүлэн технологи сэдэвт сургалтад 1 ажилтан, Ноу Хау академитай хамтран “Амжилт-Далд ухамсар” сэдэвт хувь хүний хөгжлийн сургалтыг 2020.08.28-нд зохион байгуулж, Стандартчилал, хэмжилзүйн газраас 2020.10.05-07-нд зохион байгуулсан “Стандартчилалын суурь ойлголт сэдэвт сургалтад 3 ажилтан, КОЙКА олон улсын байгууллагаас 2020.10.27-29-нд зохион байгуулсан “Төмөр замын мэдлэг олгох” сургалт 6 ажилтан хамруулсан.







“ГТХЭНТ” УТУГ-ын дүрмийн 4.2.33 болон 6.8 дугаар зүйлийн заалтыг үндэслэн “ИНЖЕНЕР-ИРЭЭДҮЙ” хөтөлбөрийг 2019-2029 онд хэрэгжүүлнэ.

Тус хөтөлбөрийн зорилго нь салбарын инженер, техникийн ажилчид, эрдэмтэн, судлаач нарын судалгаа, шинжилгээний ажил, ном, бүтээл туурвилыг дэмжих, бүтээлийн тоог нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, хөгжүүлэх, сурталчлан таниулах, салбарын мэргэжилтэн, инженерүүдийг чадавхижуулах зорилгоор олон улсад сургах, тэтгэлэгт хөтөлбөрүүдэд хамруулах, мэргэшүүлэх, туршлага судлах, сургалт, семинарт хамруулах ажлыг үе шаттай зохион байгуулахад чиглэж байна.

Салбарын инженер, техникийн ажилчид, эрдэмтэн, судлаач нарыг дэмжих, урамшуулах, шилдэг инженер шалгаруулах, бүтээлийг олон нийтэд сурталчлан таниулах, үзэсгэлэн зохион байгуулах үйл ажиллагааг таван жил тутамд нэг удаа зохион байгуулах ба тус ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

### 1. Шилдэг инженерээр шалгаруулж бүтээлийг сурталчлан үзэсгэлэн гаргасан

2019 онд “ИНЖЕНЕР-ИРЭЭДҮЙ” хөтөлбөрийг эхлүүлж Монгол Улсад төмөр зам үүсэн байгуулагдсаны 81 жилийн ой, “УБТЗ” ХНН-ийн 70 жилийн ойн баяраар “УБТЗ” ХНН-ийн Вагоны аж ахуйн албаны ахлах байцаагч А.Пүрэвбаатар, ахмад төмөр замчин Ч.Лхагвасүрэн, Улаанбаатар зүтгүүрийн депогийн ерөнхий инженер Б.Баттулга, Дохиолол холбооны 3-р ангийн кабель хариуцсан програмист инженер Д.Отгонбаяр, Замын 3-р ангийн төмөрчин токарчин Ч.Ариунболд нарыг шилдэг инженерээр шалгаруулж бүтээлийг сурталчлан үзэсгэлэн гаргасан.




## Үргэжлэл



“ГТХЗНТ” УТУГ-ын дүрмийн 4.2.33 болон 6.8 дугаар зүйлийн заалтыг үндэслэн “ИНЖЕНЕР-ИРЭЭДҮЙ” хөтөлбөрийг 2019-2029 онд хэрэгжүүлнэ.

2. Төмөр замын ажил мэргэжлийн онцлогийг хариулсан 40 гаруй видео контент бүтээж олон нийтийн сүлжээгээр түгээж, сурталчлан ажилласан.




3. Оюутан, залуу инженер, судлаач нарыг дэмжих, урамшуулах зорилгоор видео контентийн уралдаан зарлаж, урамшуулсан.



Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв  
2019.12.25

“Инженер-ирээдүй төсөл”: оролцогч Төмөр замын дээд сургуулийн Ш-4 ангийн оюутан Б. Сүхбат



4. Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэнд жил бүр мод тарьж Төвийн нэрэмжит “Инженер-Ирээдүй” төглийг бүтээн байгуулах ажлыг эхлүүлсэн. “ГТХЗНТ” УТУГ нь Мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан 2020 оны 10 дугаар сарын 09-ний өдөр “Мод хэрхэн тарих вэ?”, “Эко орчныг эргэн тойрондоо бүтээх энгийн дадал” сэдэвт сургалтыг БОАЖЯ-ны харъяа “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” УТУГ-тай хамтран зохион байгуулсан. Мөн Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэнд Төвийн нэрэмжит “Инженер-Ирээдүй” төгөлд мэргэжлийн байгууллагатай хамтарч мод тарьснаар модыг зөв технологийн дагуу тарьж ургуулах ач холбогдолтой байлаа.









“ГТХЗНТ” УТУГ-ын дүрмийн 4.2.33 болон 6.8 дугаар зүйлийн заалтыг үндэслэн “ИНЖЕНЕР-ИРЭЭДҮЙ” хөтөлбөрийг 2019-2029 онд хэрэгжүүлнэ.

Салбарын мэргэжилтэн, инженерүүдийн мэдлэг, ур чадвар, суралцах арга барил чиг хандлагыг нэмэгдүүлж, хос мэргэжилтэй болгох зорилгоор “ГТХЗНТ” УТУГ нь ОХУ-ын Эрхүүгийн зам харилцааны улсын их сургуультай санамж бичиг байгуулан төмөр замын инженер болон төмөр замд ажилладаг бусад мэргэжлийн инженерүүдийг 2020-2025 онуудад “Мэдээллийн систем ба технологи” мэргэжлээр 2,5 жилийн магистрын эчнээ хөтөлбөрт суралцуулж хамтран ажиллаж байна. Энэ сургалтын ач холбогдол нь алсын зай сургалтыг нэвтэрүүлж ажлаа хийнгээ давхар онлайн хэлбэрээр сурах, эдийн засгийг тодорхой хэмжээгээр хэмнэх зэрэг олон боломжийг бүрдүүлж байгаагаараа давуу талтай юм.



“ГТХЗНТ” УТУГ, “УБТЗ” ХНН, “ТТЗ” ХХК-ний мэргэжилтэн, инженерүүдийг 2020 оны 8 дугаар сарын 11-нээс 9 дүгээр сарын 04-ний хооронд 30 цагийн мэдээлэл технологи, орос хэлний бэлтгэл сургалтад хамруулж, сертификат олгосон. Магистрын сургалтын 1-р семестрийн хичээлийг 10 дугаар сарын 7-ноос Эрхүү хотын зам харилцааны улсын их сургуулийн доктор, профессор багш нар онлайн хэлбэрээр орж байна. “Мэдээллийн систем ба технологи” мэргэжил эзэмшнээрээ програм хангамж, техник хангамж боловсруулах, үйл явцыг хөгжүүлэх, мэдээллийн технологи болон системийг хөгжүүлэх, өөрчлөх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, төсөл удирдах зэрэг ур чадвартай, олон салбарт ажиллах боломжтой болох юм.





### “ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ” УТУГ -ЫН БАРИЛГА БАРИХ, ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧАДАВХЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЗАМААР МОНГОЛ УЛСЫН ТӨМӨР ЗАМЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ БЭХЖҮҮЛЭХ” ТӨСӨЛ

COVID-19 Цар тахлын улмаас нарийвчилсан судалгааг хийх БНСУ-ын судалгааны ажлын баг Монгол Улсад ирэх боломжгүй болж, Монгол улс дахь “КОЙКА” ОУХАБ-ын баг төслийн нарийвчилсан судалгааг хийж байна.

Энэхүү судалгаан ажлын гол зорилго нь:

- ☒ Төмөр замын хяналтын нэгдсэн системийг хөгжүүлэх, “ГТХЗНТ” УТУГ-ын чадавхыг сайжруулах талаар мастер төлөвлөгөө боловсруулах судалгаа;
- ☒ Тасралтгүй тогтвортой систем байгуулах, системийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг бий болгох судалгаа;
- ☒ Төслийг хүрээнд системийн туршилтын төсөл хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд нэвтрүүлэх судалгаа;
- ☒ Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн барилгыг барьж байгуулах шаардлагыг тодорхойлох судалгаа;



Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн төсөл хэрэгжих газартай “КОЙКА” ОУХАБ-ын судалгааны баг танилцав. Монгол Улсын төмөр замын салбарт галт тэрэгний хөдөлгөөний бодит цагийн хяналтын нэгдсэн систем, аюулгүй байдлын хяналтын систем камер ашиглан галт тэргийг вагоны дугаараар нь бүртгэх, байршлыг бодит цагаар тодорхойлох, хөдөлгөөний аюулгүй байдлыг зураг болон бичлэгээр хянах, RFID (радио давтамжит долгион)-ийн технологи ашиглан дотоодын вагон бүртгэлийн суурь системийг бий болгох, хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг тодорхойлох, хөдлөх бүрэлдэхүүний засвар үйлчилгээ ашиглалтыг сайжруулах, төмөр замын хөдөлгөөний ажлын үндсэн үзүүлэлтүүдийг бодит цагаар нэгтгэж боловсруулах улмаар төрийн хяналтын тогтолцоог сайжруулах, үр ашигтай нэгдсэн платформ бий болгохыг зорьж байна. Мөн болзошгүй эрсдэл аюулыг тодорхойлох, мэдрэгч сенсорууд тусламжтайгаар байгалийн гамшиг, болзошгүй эрсдэлийг урдчилан мэдэх, шуурхай арга хэмжээ авах замаар дохио илгээх зорилго бүхий системүүдийг туршин нэвтрүүлэхээр ажиллаж байна.